



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/929

Улаанбаатар хот

「Баянзүрх дүүргийн 8 дугаар цэцэрлэгийн  
барилга байгууламж, нийтийн эзэмшлийн  
хөрөнгийг данснаас хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэг, 80 дугаар зүйл, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 107 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын А/928 дугаар захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2017 оны 02-07-383/47 дугаар дүгнэлтээр ашиглалтын шаардлага хангахгүй болох нь тогтоогдсон Баянзүрх дүүргийн 16 дугаар хороонд байрлах нийт 401,193,625 /дөрвөн зуун нэг сая нэг зуун ерэн гурван мянга зургаан зуун хорин таван/ төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан барилга байгууламж, нийтийн эзэмшлийн хөрөнгийг актлан, данс бүртгэлээсээ хасаж, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлт хийж ажиллахыг Баянзүрх дүүргийн 8 дугаар цэцэрлэг /Я.Хандсүрэн/-т зөвшөөрсүгэй.

2. Данснаас хасагдаж буй хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулахаар үнэлсэн 5,170,300 /таван сая нэг зуун далан мянга гурван зуун/ төгрөгийн хөрөнгийг борлуулж, орлогыг Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын Нийслэлийн төрийн сангийн 100200051024 тоот дансанд төвлөрүүлж, акт болон бусад баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллахыг Захиргаа санхүүгийн хэлтэс /А.Мөнгөн/-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга Д.Рэнцэнбямбад даалгасугай.

ДАРГА

М.БАЯРАА

115060001611

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын  
газрын даргын 2020 оны 12 дугаар сарын  
25-ний өдрийн 17/629 тушаалын хавсралт



НИЙСЛЭЛИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛЭЭС ХАСАХ БАРИЛГА,  
БАЙГУУЛАМЖ, НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХӨРӨНГӨ

Төгрөгөөр

№	Эд хөрөнгийн дүн	Ашигласан жил	Хэмжих нэгж	Биет хэмжээс /м <sup>2</sup> /	Нэгжийн үнэ	Нийт үнэ	Байгуулсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Цэцэрлэгийн барилга	63	ш	388	398,366,000	398,366,000	398,366,000	0
2	Хүнсний склад	7	ш	-	1,402,125	1,402,125	1,402,125	0
3	Нийтийн эзэмшлийн талбай	63	ш	40	1,425,500	1,425,500	1,425,500	0
Нийт үнэ						401,193,625	401,193,625	0